



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/28

Баянбулаг

Г Сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ийн хэрэгжилтийг хангах, хэлний бодлогын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажил арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг чанартай зохион байгуулж, тайлан мэдээг цаг тухай бүрд танилцуулахыг О.Болормаа (Хэлний бодлогын салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажлуудыг зохион байгуулахад холбогдож гарах зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Холбогдох санхүүгийн тайлан баримтыг бүрэн бүрдүүлж ажиллахыг Тамгын газрын нягтлан бодогч Г.Түмэнболдод даалгасугай.

ДАРГА  Н.ГАНСҮХ



642301049